

МИНИЙ АЖИЛ, АМЬДРАЛЫН ГАРАА М.ДҮГЭРСҮРЭН САЙДТАЙ САЛШГҮЙ ХОЛБООТОЙ

Л. Эрдэнэчулуун*

Монгол улсын гадаад харилцааны нэрт зүтгэлтэн, дипломатч, Монгол Улсын Гадаад хэргийн сайд асан М. Дүгэрсүрэн гуайн 85 насны ойд зориулан зохион байгуулж буй энэхүү эрдэм шинжилгээний бага хуралд оролцогсод Эрхэм хүндэт Та бүхний амрыг эрье.

Монголын гадаад бодлогыг хэрэгжүүлэх үйлст М. Дүгэрсүрэн гуайн эзэлж байсан орон зай, Монголын гадаад харилцааг хөгжүүлэхийн төлөө түүний хийж бүтээсэн бүхнийг, түүний гавьяа зүтгэлийг тод томруун харуулах, Монголын гадаад бодлогын гол хөтөч Гадаад хэргийн яамны бодлого, зорилтыг тодорхойлоход энэхүү бага хурлын ач холбогдол чухал бөгөөд түүнд үнэтэй хувь нэмэр оруулна гэж бодож байна.

Өнөөдөр энд үг хэлсэн, илтгэл тавьсан Та бүхэн Монгол төрийн шинэ үеийн дипломат бодлогыг хөтлөн явуулах, түүнийг амжилттай хэрэгжүүлэхэд М.Дүгэрсүрэн гуайн байгуулсан их гавьяа зүтгэлийг нэгэнт тодорхой дүгнэж хэлсэн болохоор энэ талаар давтаж олон зүйл нуруших хэрэггүй юм.

Тэглээ ч, Монголын шинэ үеийн гадаад харилцааг хөгжүүлэх, Монгол улсын Гадаад хэргийн яамыг дэлхийн жишигт хүргэн зохион байгуулж өнөөгийн бодит байдал, дүр төрхийг бий болгох, дипломат ажилтнуудыг бэлтгэхэд М.Дүгэрсүрэн сайдын оруулсан хувь нэмрийг дурсан санахгүйгээр, онцгойлон дурьдахгүйгээр өнгөрч боломгүй байна.

М.Дүгэрсүрэн гуай бол орчин цагийн Монголын мэргэжлийн анхны дипломатчдын нэг, өөрийн амьдралын үлэмжхэн хэсгийг эх орныхоо гадаад бодлогын салбарт зориулж, Монгол улсын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд

* Гадаад хэргийн сайд асан, Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд

дорвитой хувь нэмэр оруулсан нэрт дипломатч байсан. Чухамхүү энэ хүн л Гадаад хэргийн яамны түүхэнд 17 жил буюу хамгийн удаан ажилласан сайд байсан юм.

Монгол улсын гадаад харилцаа өргөжиж, 1961 онд манай орон НҮБ-ын бүрэн эрхт гишүүн болж, улмаар түүний системийн олон байгууллагад элсэж орсон, Монгол улс дэлхийд өөрийн байр суурийг баттай эзэлж, нэр хүнд нь өссөн явдал түүний зүтгэл, үйл ажиллагаатай ихээхэн хэмжээгээр холбоотой байсан гэж хэлэх үндэс бий. Нэг хүний ухаалаг үйл ажиллагаа, дипломатын өндөр ур чадвар дэлхий нийтэд өндөр үнэлэгдэж, Монгол мэтийн жижиг орны нэр хүндийг ч олон улсын тавцанд өргөж өгдөг юм байна гэдгийг М.Дүгэрсүрэн сайдын үйл ажиллагаа тодоос тод харуулдаг.

Монгол улсын гадаад харилцаа хоёр талын хамтын ажиллагааны хүрээнээс хальж, олон талт хамтын ажиллагааны гольдролд орсноор Гадаад хэргийн яамны үүрэг, бүтээлч ажиллагаа улам бүр өсөн нэмэгдэж, дипломат ажилтнуудад тавигдах шаардлага улам өндөржиж, жинхэнэ мэргэжлийн, чадварлаг дипломатчдыг бэлтгэх зорилт ч зүй ёсоор тавигдаж эхэлсэн юм. М.Дүгэрсүрэн сайд ч энэ талаар ихээхэн анхаарал тавьж байсныг бид мэднэ.

М. Дүгэрсүрэн сайд улс төрийн болон дипломат ажлын өргөн мэдлэгтэй, гадаад бодлогын асуудлыг нарийн ойлгодог, мэдрэмж сайтай, ажилсаг, чамбай, хариуцлагатай хүн байсан. Түүний өөртөө болон бусдад тавьдаг өндөр шаардлага, нягт нямбай ажиллагаа, цаг үе, нөхцөл байдлаа үнэлэх нарийн мэдрэмж гадаад харилцаанд ажилладаг хүмүүст үлгэр дуурайлал болдог байсан гэдгийг түүний удирдлагын доор 20 гаруй жил ажилласны хувьд өнөөдөр энд дурсан хэлэхэд таатай байна.

М.Дүгэрсүрэн гуай зөвхөн дипломатч төдийгүй мөн эрдмийн хүн байсан гэж би боддог. Хийж бүтээснээс нь үзэхэд ч үнэхээр тийм байна. Тэр хүний боловсруулсан гадаад бодлогын баримт бичиг, бичсэн ном, бүтээл, бусад материалыг харахад үнэхээрийн эрдэм шинжилгээний өндөр түвшинд хийсэн сайхан ажлууд байдаг. 1971 онд түүний боловсруулж гаргасан Монгол улсын гадаад бодлогын үечиллийн асуудлаарх товхимол нь манай улсын гадаад бодлогыг түүхэн талаас нь үечилж ул суурьтай хандсан бүтээл болсон. Дипломатч агсан О.Хосбаяр гуайтай хамтран туурвисан “Олон улсын эрх зүй”, “Дипломат алба, дипломат ажиллагааны үндэс”, Гадаад хэргийн сайд асан

Ц.Гомбосүрэн гуайтай хамтран бичсэн “Монгол улсын ХХ зууны гадаад бодлого”¹ нэртэй номууд нь эх хэлээр гарсан мэргэжлийн анхны сурах бичгүүд бөгөөд олон улсын харилцааны чиглэлээр суралцаж буй оюутан, багш нарын ширээний ном болсон гэдэг нь дамжиггүй.

Миний ажил, амьдралын гараа М.Дүгэрсүрэн сайдтай салшгүй холбоотой. 1970 онд М.Дүгэрсүрэн сайдыг НҮБ-д суугаа манай Байнгын төлөөлөгч байхад нь Москвагийн Олон улсын харилцааны дээд сургуулийн төгсөх ангийн оюутан миний бие дадлага хийхээр анх Нью-Йоркт очиж байсан юм. Түүнээс хойш НҮБ-ын дэргэд суух Байнгын төлөөлөгч, Элчин сайд хүртэлх 30 гаруй жилийн миний ажил, амьдрал тэр хүнтэй холбоотой байсан бөгөөд тэр тухай бодоход сэтгэлд дулаан байдаг юм.

М.Дүгэрсүрэн сайдын гэгээн дурсгалыг хүндэтгэн ажил үйлсийг нь мөнхжүүлж байгаа эрдэм шинжилгээний энэхүү бага хуралд оролцож байгаа завшааныг ашиглан орчин үеийн Монгол улсын гадаад бодлогын талаар өөрийн бодож санаж явдаг зарим зүйлээ хэлье гэж бодож байна.

ХХ зууны эхэн үеэс чухамхүү Монгол улс олон улсын тавцнаа гарах, бие даасан гадаад бодлого явуулах боломж нээгдсэн юм. Тэр цагаас Монгол улс өөрийн гадаад бодлогоо бие даан явуулахыг хичээн эрмэлзэж, улсынхаа тусгаар тогтнолыг умард, өмнөд хөршөөрөө хүлээн зөвшөөрүүлэх, улмаар эрх тэгш, хэвийн харилцаа тогтоох, тухайн үед дэлхийн бодлогыг тодорхойлж байсан томоохон улс гүрнүүдтэй харилцаа холбоо тогтоохыг чухалчилж ажилласан. Энэ нь угтаа улс орныхоо тусгаар тогтнолыг олон улсын эрх зүйн хүрээнд баталгаатай болгох гэсэн шинэ цагийн Монгол улсын гадаад бодлогын эрчимтэй үйл ажиллагааны эхний үе шат байлаа.

Тэртээ 90-ээд жилийн өмнө ахмад үеийнхний маань санаж хүсэж байсан төрийн тусгаар тогтнол, зориглон эхлүүлсэн бие даасан гадаад бодлогыг залгамжлан явуулахад ололт амжилтын зэрэгцээ хүндрэл бэрхшээл багагүй байсан. Монгол улс туурга тусгаар улсаа сэргээхэд 1921 оны хувьсгал, тусгаар тогтнол, бие даасан байдлаа бусад гүрнүүдээр хүлээн зөвшөөрүүлэхэд 1945 оны Ялтын хэлэлцээр чухал үүрэг гүйцэтгэсэн гэдгийг та бид сайн мэдэж байгаа.

Олон жилийн туршид уйгагүй хүчин чармайлт гаргасны үр дүнд 1961 онд НҮБ-ын бүрэн эрхт гишүүн болсон нь Монгол улсыг олон улсын зүгээс хүлээн зөвшөөрсний

¹ “Олон улсын эрх зүй” номыг 1996, “Дипломат алба, дипломат ажиллагааны үндэс” номыг 1998, “Монгол Улсын 20 дугаар зууны гадаад бодлого” номыг 2003 онд тус тус гаргажээ.

гол нотолгоо болсон юм. Гэхдээ Монгол улс НҮБ-д үйл ажиллагаагаа явуулахдаа тэр үеийн социалист системийн орнуудын жанжин шугамыг даган баримталж, өөрөөр хэлбэл социалист систем капиталист тогтолцооноос давуутайг харуулах, АНУ, бүхэлдээ Өрнөдийн орнуудын эсрэг байр сууриа харуулах зорилгод үйлчилж байсан. Өөрөөр хэлбэл, НҮБ-ыг ард түмнүүдийн харилцан ойлголцол, яриа хэлэлцээг урагшлуулах индэр болгох бус үзэл суртлын зорилгод ашиглаж байсныг дурьдах хэрэгтэй. Харин өнөөдөр бид энэ байгууллагын бие даасан, ихээхэн идэвх санаачилгатай гишүүн нь болж чадсанаа тэмдэглэхэд таатай байна.

Олон улсын харилцаанд ноёрхож байсан “Хүйтэн дайн” дуусч хоёр туйлт ертөнц задран унаснаар манай улс өөрийн гэсэн хөгжлийн замналыг сонгон авч, бие даасан гадаад бодлого хэрэгжүүлэх аятай, таатай нөхцөл түүхэн цаг үетэй золгосон юм.

Манай оронд ардчилсан ёс, олон ургалч үзэл, зах зээлийн эдийн засгийн замыг сонгон авсан хийгээд улс төр, нийгэм, эдийн засгийн салбарт тууштай өөрчлөлт, шинэчлэл хийж эхэлсэн нь улс үндэснийхээ ашиг сонирхлыг дээдэлсэн, бодит байдалд тулгуурласан гадаад бодлого явуулах боломжийг бүрдүүлсэн юм. Олон ишт, нээлттэй, нэгдмэл гадаад бодлогын зарчмыг баримтлан хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлсэд тулгуурлан бүх улс оронтой найрсаг харилцах, олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлэх, эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хангах нь Монгол улсын гадаад бодлогын эрхэм зорилт болж байгаа билээ.

Бидний амьдарч буй энэ цаг үе, даяаршлын эрин үед олон улсын харилцаа, хамтын ажиллагааны үүрэг оролцоо, ач холбогдол улам бүр өсөн нэмэгдэж байна. Өнөө үеийн манай гадаад бодлого нь улс орны хөгжил цэцэглэлтийг хангахад нэн чухал, үр нөлөө бүхий хэрэгсэл болон хувирч байгааг хэлмээр байна. Өнөөдөр, гадаад харилцаанд оролцдоггүй тийм төрийн бэлон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, нарийндаа хувь хүн ч гэж бараг үгүй болоод байна. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа ийнхүү өргөн хүрээг хамрах болсноор дипломатчид болон гадаад харилцааны салбарт ажиллагчдын үйл ажиллагааны зааг хязгаар, хүрээ өргөжин тэлж, улам бүр шинэ зорилт, өндөр хариуцлага тулгарч байна.

Улс түмний уялдаа холбоо, харилцан хамаарал улам бүр өсөн нэмэгдэхийн хирээр улс орнууд дангаар шийдэх боломжгүй асуудлууд, тухайлбал, олон улсын терроризм, ядуурал, экологийн тэнцвэргүй байдал, байгаль орчны доройтол, хууль бус цагаачлал, халдварт өвчний тархалт, хар тамхи, зэвсгийн болон хүн наймаалах гэмт хэргүүд,

үндэстэн хоорондын мөргөлдөөн зэрэг шинэ шинэ бэрхшээлүүдтэй тулгарах боллоо. Манай улс ч ийм бэрхшээлүүдийн зах зухаас нь амсах болсон нь олон улсын болон бүс нутгийн хэмжээнд харилцаа, хамтын ажиллагаагаа улам бүр идэвхжүүлэн бэхжүүлэхийг шаардаж байгааг харуулж байна.

Эдүгээ аюулгүй байдлын асуудал нь үзэл баримтлалын хувьд шинэ ойлголт, агуулгаар өргөжин, хамрах хүрээний хувьд улам бүр тэлж ирсэн гэдгийг тэмдэглэх нь зүйтэй болов уу. Аюулгүй байдлын тухай асуудал нь бидний анхаарлыг газар нутгийн аюулгүй байдлын талаарх уламжлалт асуудлаас илүүтэй хувь хүн дээр төвлөрүүлэх боллоо. Тухайн хувь хүн айх аюулгүй, эрүүл саруул, сэтгэл хангалуун амьдарч, амьдралын түвшин ямар байгаагаар улс орны хөгжлийн түвшин улам бүр тодорхойлогдох болж байна. Тиймээс ч төрийн үйл ажиллагааг хүний аюулгүй байдлын асуудлыг хэр зэрэг буурьтай, үр нөлөөтэй шийдвэрлэж байгаагаар нь дүгнэдэг болжээ. Ийм шалгуур үзүүлэлтийг ч гадаадын томоохон хандивлагч улс орнууд, олон улсын байгууллагууд Монгол улсад тавьж хандах болсон гэдгийг өнгөрсөн 10 гаруй жилийн үйл ажиллагаа тод харуулж байгаа. Энэ нь 21 дүгээр зуун хүн төвтэй зуун болохын учир утгыг ч өгүүлж буй хэрэг юм.

Дашрамд хэлэхэд, миний бие 2003 онд “Хүний аюулгүй байдлын судалгааны төв”-ийг байгуулж аюулгүй байдал, гадаад бодлогын болоод нийгэм, социологийн чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг олон улсын байгууллагуудтай хамтран хийж байгаа билээ. Манай судалгааны төв 2006 онд Монголд амиа егүүтгэгсдийн талаар судалгаа хийсэн юм. Уг судалгаагаар 2004 онд амиа егүүтгэгсдийн тоо 216 байсан бол 2005 онд 417 буюу бараг хоёр дахин өссөн тоо байдаг. 1999-2004 онд амиа егүүтгэгсдийн дундаж тоо 200 гэсэн судалгааг гаргасан юм. Ийнхүү амиа егүүтгэх болсон гол шалтгаан нь нийгэм, сэтгэл зүйн шалтгаан буюу ажилгүйдэл, ядуурал, бусад гадны дарамтаас үүдэлтэй байсан байх юм².

“Гадаад бодлогын үзэл баримтлал”-ыг шинэчлэх талаар

1990-ээд оноос хойш олон улсын харилцаанд гарсан их өөрчлөлт, хувьсал нь Монгол улсын гадаад орчинд эрс нөлөөлсөн. Шилжилтийн энэ үеийн манай улсын гадаад бодлогыг “Үндэсний аюулгүй байдал”-ын болон “Гадаад бодлогын үзэл баримтлал”-

² “Монгол дахь амиа хорлогсдын талаарх судалгаа”, Хүний аюулгүй байдлын судалгааны төв, 2006 он

уудад хуульчлан тунхаглаж, 1996, 2000, 2004 оны Засгийн газруудын үйл ажиллагааны хөтөлбөрийн гадаад бодлогын зорилтуудад тухай бүрт нь тодотгон тодорхойлж, хэрэгжүүлсээр ирсэн. Эрх зүйт төртэй ардчилсан улсын гадаад бодлогод гэнэтийн хувиралт, огцом эргэлт гардаггүйг бид үзэл баримтлалыг мөрдөж ажилласан 10-аад жилээр нотлон харууллаа. Манай аль ч Засгийн газрын үед гадаад харилцаа, хамтын ажиллагаа өргөжин тэлж байсан гэж дүгнэж болно.

Харьцангуй бие даасан, тэнцвэртэй, идэвхтэй гадаад бодлого явуулж, аюулгүй байдлаа хангахдаа зөвхөн нэг улсад бус аль болох олон улс, олон улсын байгууллагуудыг түшиглэн, олон улсын эрх зүйд тулгуурласан үйл ажиллагаа явуулах нь энэ бодлогын мөн чанар байсан бөгөөд тэр нь ч өнгөрсөн жилүүдэд харагдлаа. Нөгөө талаас, манай улсын гадаад аюулгүй байдлын орчинд сүүлийн арав гаруй жил харьцангуй таатай нөхцөл бүрдсэнээр үндэсний ашиг сонирхолд нийцсэн, харьцангуй бие даасан гадаад бодлогоо хэрэгжүүлэн улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлөө хурдасгах, аюулгүй байдлаа бэхжүүлэх өргөн бололцоо бий болсон. Энэ бололцоог ч бид алдаагүй юм.

1994 оноос хойш гадаад бодлого, гадаад харилцааны үндсэн чиг шугамыг хуульчлан томъёолж хэрэгжүүлсээр ирсэн. Энэ бодлогын хүрээнд юуны өмнө хоёр хөрштэйгээ тэнцвэржсэн, идэвхтэй бодлого явуулж тэр зорилгодоо ч хүрсэн юм. Идэвхгүй байдалд ороод байсан Монгол-Оросын харилцааг чанарын шинэ шатанд гаргаж, олон жилийн туршид шийдлээ хүлээж байсан томоохон асуудлуудыг хоёр талын хүчин чармайлтаар нааштайгаар зохицуулж чадсан. ОХУ-тай харилцаа, хамтын ажиллагаагаа “Сайн хөршийн, уламжлалт түншлэл”³-ийн үзэл санааны дагуу хөгжүүлж байгаа бол өмнөд их хөрш-БНХАУ-тай “Сайн хөршийн харилцан итгэсэн, түншлэлийн харилцаа”⁴-нд хүргэж, харилцаа, хамтын ажиллагааг тус тус шинэ шатанд гаргаж ахиулж чадсан.

Монгол улсын гадаад бодлогод АНУ-тай харилцах асуудал онцгой байр эзэлж байна. Хоёр талын харилцаанд ойлголцол, итгэлцэл нэмэгдэж, АНУ-ын гадаад бодлогод манай улсын эзлэх орон зай тэлж, ойр дотно уур амьсгал бий болсон гэж хэлэх бүрэн үндэс бий. 2004 онд Монгол улсын Ерөнхийлөгчийн тус улсад хийсэн айлчлалын үеэр

³ ОХУ-ын Ерөнхийлөгч В. Путины Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлал – Улаанбаатарын тунхаглал, 2000 оны 11 дүгээр сар.

⁴ БНХАУ-ын дарга Ху Жинтаогийн Монгол Улсад хийсэн төрийн айлчлал – Хамтарсан мэдэгдэл, 2003 оны 5 дугаар сар.

хоёр талын харилцааг “Иж бүрэн түншлэл”-ийн үзэл санааны дагуу хөгжүүлэхээр баримт бичиг байгуулсан⁵ нь Монгол-АНУ-ын харилцааны түүхэнд шинэ алхмыг хийсэн юм.

Манай улсын Ази дахь гол түнш - Япон улстай харилцаа, хамтын ажиллагаа бүхий л салбарт өргөн хүрээг хамарч, “Иж бүрэн түншлэл”-ийн хэмжээнд хөгжиж байна. Одоо хоёр орон энэхүү “Иж бүрэн түншлэл”-ийн хүрээнд харилцааг бүх салбарт урт хугацаанд, тогтвортой хөгжүүлэх, улмаар Монгол улс нь хандив, тусламж авдаг бус харилцан ашигтай хамтын ажиллагаа бүхий түнш орон болох нь чухал байна. БНСУ-тай хамтын ажиллагаа эрчимтэй хөгжиж эдүгээ хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа бие биенээ нөхсөн шинжтэй болж өргөжин хөгжиж байна. “Оюун санааны хөрш” гэдэг утгаар БНЭУ-тай түлхүү харилцахыг эрмэлздэг. Мөн Турк, АСЕАН-ы орнуудыг бид хоёр талын болон олон талын харилцаандаа түншлэгч гэж үзэж идэвхтэй гадаад бодлого явуулдаг. Цаашлаад Европын холбоо, түүний гишүүн гол гол орнуудтай, ялангуяа ХБНГУ-тай түлхүү харилцахыг чухалчилдаг.

Гадаад бодлогын үзэл баримтлалыг хэрэгжүүлж ажилласнаас хойш буюу өнгөрсөн 17 жилийн хугацаанд дэлхий дахинаа глобаль болон бүс нутгийн хэмжээний өөрчлөлтүүд гарч Монгол улсын аюулгүй байдлын гадаад орчинд урт хугацаанд зонхилох нөлөө үзүүлэх, улмаар улс орны гадаад бодлогыг тодорхойлох хүчин зүйлүүд бий болж байна.

Энд юуны өмнө бидний төдийлөн төсөөлж байгаагүй даяаршлын үйл явцын нөлөөлөл Монголын эдийн засаг, нийгэм, улс төр, соёлын бүх салбарт эерэг, сөрөг байдлаар тусч, харилцан хамаарал нь улс орны байдлыг тодорхойлогч нэг чухал хүчин зүйл болов. Олон улсын тавцанд ялангуяа Ази, Номхон далайн бүс нутагт өрнөж буй улс төр, эдийн засаг, цэрэг зэвсгийн салбар дахь өөрчлөлт, хувиралт нь Монголын байдалд шууд ба шууд бусаар нөлөөлөөд зогсохгүй, зарим талаар манай хөгжлийн хувь заяаг тодорхойлоход хүрч байна. Үндэстэн хоорондын мөргөлдөөн, түүнээс үүдэлтэй иргэдийн цагаачлал, хүнс тэжээлийн хомсдол болон олон улсын терроризм, байгаль цаг уурын өөрчлөлт, халдварт өвчин зэрэг нь өдгөө хамгийн их ноцтой асуудал болоод байна. Зөвхөн нэг баримт дурдахад 1990-2004 оны хооронд дэлхий дахинаа 57 зэвсэгт мөргөлдөөн гарснаас 4 нь улс хоорондын, 53 нь улс дотроо буюу үндэстэн хоорондын мөргөлдөөн байсан байх юм. Түүнээс Ази тивд 15 мөргөлдөөн гарсан байна. Харин нэг

⁵ Монгол Улсын Ерөнхийлөгчийн АНУ-д хийсэн албан ёсны айлчлал – Хамтарсан мэдэгдэл. 2004 оны 7 дугаар сар.

нааштай үзүүлэлт нь 1991 оноос хойш зэвсэгт мөргөлдөөний тоо буурах хандлагатай буюу сүүлийн 15 жилд 40 хувиар буурсан бол олон улсын террорист үйл ажиллагаа, түүнд өртөгсдийн тоо эрс өсчээ. 1968-1984 онд олон улсын террорист ажиллагаанд 3 мянган хүн амиа алдсан бөгөөд энэ нь 2001 оны 9 дүгээр сарын 11-ний террорист ажиллагаанд өртсөн нийт хүн амын тоотой тэнцэж байгаа ажээ⁶. Энэ нь олон улсын терроризм юу юунаас илүү аюултай, хор нөлөөтэй болохыг харуулж байгаа тод баримт юм.

Дархлал хомсдлын хам шинж өвчнөөр /ДОХ/ өдөрт 8 мянган хүн нас барж байгаагаас ихэнх нь хүүхэд, залуучууд байна. Мөн хумхаа /малярия/ өвчнөөр өдөрт 3 мянган хүүхэд, сүрьеэ өвчнөөр 6 мянган хүн амиа алдаж байна гэсэн тоо бий. Дээрх 3 төрлийн халдварт өвчнөөр жилд 6 сая хүн нас барж байгаагаас ихэнхдээ нэн буурай, буурай хөгжилтэй орнуудыг хамарч байгаа ажээ⁷. НҮБ-ын Аюулгүйн зөвлөл болон АНУ-ын ҮАБЗ-өөс гаргасан илтгэлд халдварт өвчнүүд ийнхүү ихээхэн газар авах болсны хамгийн гол аюул нь улс орнуудын улс төрийн тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэхэд хүргэсэнд оршино.

Хар тамхи, зэвсгийн наймаа нь өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд хамгийн их цэцэглэн хөгжиж байгаа бизнес болжээ. ОУВС-гийн гаргасан судалгаагаар хар тамхины наймааны орлого жилд 400 тэрбум доллар байгаа нь зохион байгуулалттай гэмт хэргийн 50 хувийг эзэлж байгаа буюу тухайлбал, Испани улсын ДНБ-тэй тэнцэж байна. Хар тамхины наймаанд дэлхийн хүн амын 3 хувь буюу 185 сая хүн шууд ба шууд бусаар татагдан оржээ⁸.

Гэхдээ дээрх хүчин зүйлүүд нь өдгөө баримталж буй “Аюулгүй байдал”-ын болон “Гадаад бодлогын үзэл баримтлал”-ыг өөрчлөх нөхцөл, шалтгаан хараахан биш гэж бодож байна. 1990-ээд оноос хойш хоёр туйлт систем задран унаж, улс төр, нийгмийн шинэ тогтолцоо бүрэлдсэнтэй холбоотойгоор аюулгүй байдлын болон гадаад бодлогыг агуулга, хэлбэрийн хувьд цоо шинээр авч үзэх улмаар өөрийн үзэл баримтлалтай болгоход хүргэсэн билээ. Нөгөө талаар аливаа концепци буюу үзэл баримтлал гэдэг нь ерөөс аливаа үйл ажиллагааны хөгжлийн хэтийн зорилт, зааг хязгаарыг тогтоосон стратегийн баримт бичиг байдаг болохоос бус үе үе өөрчлөөд байх зүйл биш юм.

⁶ *Le Monde diplomatique, Edition speciale – Hors serie 2006*

⁷ *Programme des Nations unies pour le developpement, Rapport mondial sur le developpement humain 2005.*

⁸ *Rogers and Randolph, The global spread of malaria in a future, warmer world, Sciences № 289d 2005*

⁸ *Rebeca Surtees, Second Annual Report on Victims of Trafficking in South-Eastern Europe 2005.*

Одоогийн мөрдөж буй үзэл баримтлал нь манай гадаад бодлогын зорилт, чиглэл хүрээг бүхэлд нь тодорхойлж, арга замыг томъёолсон боловсронгуй баримт бичиг гэж би хувьдаа үздэг.

Үзэл баримтлалд гадаад бодлогын салбаруудаар нь хэт нарийвчлан авч үзсэн, тэргүүлэх чиглэлийг нь зургаан хэсэгт хувааж, бүлэглэсэн нь түншээ алагчилж дугаарласан болхи хуваарь болсон, бодлогоо тодорхойлохдоо зарим чиглэлд хэт явцуу хүрээнд, уян хатан бус байдлаар зааж өгсөн гэх мэтээр манай зарим судлаачид шүүмжлэх явдал байдаг.

Төгс төгөлдөр зүйл гэж байдаггүйтэй адил “Гадаад бодлогын үзэл баримтлал”-д ч эргэн харах, засаж залах зүйл гарах нь ойлгомжтой. Энэ агуулгын үүднээс манай гадаад харилцааны өнгөрсөн 10 жилийн үйл ажиллагаанд дүгнэлт хийж, улмаар үзэл баримтлалд туссан гадаад бодлого, харилцааны зарим чиглэлийг цааш нь нарийвчлан тодотгож, бодлогын зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх нөхцөл, арга замыг тодорхойлох зорилгоор миний бие Гадаад хэргийн сайд байхдаа “Гурав дахь хөрш”-ийн үзэл баримтлалыг боловсруулж ҮАБЗ-д танилцуулж байсан билээ.

“Гурав дахь хөрш”-ийн үзэл баримтлалын тухай АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга асан Ж. Бейкерийн манай улсад хийсэн айлчлалын үеэр “Монгол улс гурав дахь том хөрш - АНУ-тай сайн харилцаатай байж болох юм гэж боддог”⁹ хэмээн илэрхийлснээс хойш “Гурав дахь хөрш”-ийн тухай ярьцгааж тэр нь АНУ байх юм шиг зарим хүмүүс ойлгож ирсэн. Тэр ч байтугай зарим Засгийн газрын албан ёсны хөтөлбөрт ч энэ тухай дурьдаж АНУ манай улсын цорын ганц өмөг түшиг, аюулгүй байдлын баталгаа мэтээр нимгэн түргэн ойлгож байсан тал бий¹⁰. Ж. Бейкерийн хэлсэн үгийн хувьд тухайн үеийн АНУ-ын засаг захиргаа Монгол улсын ардчилал, зах зээлийн харилцаанд шилжиж буй үйл явцад улс төрийн дэмжлэг үзүүлэх гэсэн агуулгаар ярьж байсан болов уу.

Тухайн үедээ, манайхны хувьд “Гурав дахь хөрш” гэдгийг чухам ямар агуулгаар авч үзэх, яаж тодорхойлох вэ гэдэг талаар нэгдсэн санаа, бодолгүй, янз бүрийн ойлголтууд байсан нь үнэний хувьтай.

⁹ АНУ-ын ТНБД Ж. Бейкерийн Монгол Улсад хийсэн айлчлалтай холбоотой баримт бичиг – ГХЯ-ны төв архив – 1990 он.

¹⁰ 1996 онд байгуулагдсан Эвслийн Засгийн газрын мөрийн хөтөлбөрт энэ тухай тодорхой туссан байсныг зохиогч тухай үедээ жүүмжилж байв.

Тиймээс ч “Гурав дахь хөрш”-ийн үзэл баримтлалыг томъёолж, төр засгийн түвшинд албан ёсны нэгдсэн ойлголттой болох нь чухал байсан. Учир нь манай оронд тохиож болох улс төр, нийгэм эдийн засгийн сөрөг хүчин зүйлүүдийг даван туулахад энэхүү үзэл баримтлал чухал үүрэгтэй гэдгийг ямагт бодолцох учиртай юм.

Ер нь “Гурав дахь хөрш”-ийн тухай ойлголт нь шинэ тутамд гарч ирсэн санаа биш юм. 1911 онд Богд Хаант Монгол улс байгуулагдсан цагаас хойш аль болох олон улс орнуудтай харилцахыг эрмэлзэж байсан нь угтаа “Гурав дахь хөрш” нь ямар улс байх санааг агуулж байсан бөгөөд харин тэр санаагаа цэгцтэй ойлгох, томъёолох талаар оролдлого хийж байсангүй.

“Гурав дахь хөрш”-ийн үзэл баримтлал нь “Монгол улсын үндэсний аюулгүй байдал”-ын болон “Гадаад бодлогын үзэл баримтлал”-д заасан улс орны аюулгүй байдлыг хангах, гадаад бодлого, гадаад харилцааг хөтлөн явуулах үйл ажиллагааны зарим чиглэлийг шинэ зуун, даяаршлын шинэ нөхцөл байдалд зохицуулан дэлгэрүүлэн тодотгож, энэ талаарх төрийн бодлогын зорилт, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлоход орших учиртай гэж үзэж байна.

Үзэл баримтлалын гол агуулга нь Монгол улсын хувь заяа, үндэсний аюулгүй байдал болон хөгжил дэвшлийн асуудал зөвхөн хоёр хөршөөс хамаарч нөхцөлдөж байх бус, мөн дэлхийн том гүрнүүдийн стратегийн сонирхол, оролцоо, нөлөө хамаарлаас давхар шалтгаалж байх нөхцлийг бүрдүүлэхэд оршиж байгаа болно. Мөн “Гурав дахь хөрш” гэдэг нь зөвхөн газар зүйн бус, улс төр, эдийн засгийн хүрээг хамарсан цогц ойлголт бөгөөд энэ нь аль нэг тодорхой гуравдагч орныг бус, Монгол улсын ардчиллыг тууштай дэмжигч өрнө, дорны орнуудын бүлэг болон олон улсын байгууллага, дэлхийн бодлогод жин нөлөөтэй субъектыг оруулж буй өргөн ухагдахуун, ойлголтыг агуулсан томъёолол юм. Өөрөөр хэлбэл манай улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал, үндэсний эрх ашиг, хөгжил дэвшилд өнөө ирээдүйн уламжлалт хүчин зүйлсийн зэрэгцээ хоёр хөршийн төдийгүй, дэлхийн өндөр хөгжилтэй нөлөө бүхий улс гүрнүүдийн стратегийн сонирхол, харилцан нөлөөлөл, хамаарлаар давхар баталгаажиж байх нөхцлийг бүрдүүлэхэд гол санаа нь оршиж байгаа юм.

Гэхдээ энэ нь манай зарим “онолчид”, судлаач, улс төрчдийн үзэж байгаа члан “Гурав дахь хөрш”-ийн тухай ойлголт нь хойд, өмнөд хоёр хөршөө хооронд нь эвдрэлцүүлэх, зөрчилдөөнийг бий болгох бус, Монгол улсын улс төр, аюулгүй байдлын

асуудал нь зөвхөн хоёр хөршөөс хамааралтай байх бус дэлхийн томоохон улс орнууд болон олон улсын зарим байгууллагын стратегийн ашиг сонирхлыг адил тэнцүү татаж байхад орших ёстой юм. Хамгийн чухал нь Монгол улс нь хоёр хөршийн аль нэгнээс болон хоёулангаас нь цэрэг, улс төрийн болон эдийн засгийн талаар хараат байдалд орохоос сэрэмжлэн сэргийлсэн бодлого, үйл ажиллагаа явуулахад “Гурав дахь хөрш”-ийн үзэл баримтлалын гол агуулга чиглэгдэх учиртай гэдгийг л ухааруулж байгаа хэрэг юм. Дээр өгүүлсэн аль ч сэдвээр тодотгон ярилцаж, санаа бодлоо солилцох, үр дүнтэй маргаан мэтгэлцээн өрнүүлэхэд миний бие хэзээд бэлэн гэдгээ үгийнхээ төгсгөлд хэлье!

Анхаарал тавьсанд баярлалаа.